

БУДДЫН БА ӨРНИЙН ФИЛОСОФИЙН ҮЗЛИЙГ ХАРЬЦУУЛАХУЙ

Доржан Мархаев - МУИС-ийн Шашин судлалын тэнхмийн докторант

Түлхүүр үгс: Хоосон чанар, үнэмлэхүй, харьцангуй, матер, ухамсар, Зонхав, Далай лам, Платон, Кант, Гегель, Маркс

Товч утга: Би энэхүү өгүүлэлдээ их Зонхав Богдын “Мөрийн гурван үндэс” бүтээлийн агуулгыг Далай ламаас тайлбарлан айлдсан айлдваруудыг үзэл санааныхаа гол баримтлал болгон авлаа. Учир нь, материаллаг болон материаллаг бус байдлаар оршин буй бүхний шүтэн барилдлагыг ухаарсан Далай ламын гүн гүнзгий ухаарал үнэндээ миний бишрэх сэтгэлийг ихэд хөдөлгөсөн билээ. Барууны судлаачдын хэлж заншсан “түүнчлэн чанар” хэмээх ойлголт нь утгаа хоосон чанар буюу төвдөөр «Tong nyid», бүх юм үзэгдлийн хоосон мөн чанарыг илэрхийлнэ. Шуньята буюу хоосон чанар нь “бодьтой буй бүхэн” мөн, бүхний дээд бодит байдал, зайлшгүй болох ёстой зүйл, оюуны бясалгалын дээд зорилго мөн бөгөөд орчин үеийн шинжлэх ухааны ололтыг зөрчилт бус байдлаар ухаарах тэр судлагдахуун мөн болой.

Их багш Зонхав богдын “Мөрийн гурван үндэс” хэмээх гайхамшигт бүтээлийн агуулгыг эдүгээчилсэн, эсвэл шүүмжлэн хэлэлцсэн, тэр ч бүү хэл бурханы шашинаас тэс өөр үзэл суртлын үүднээс авч үзсэн судалгаа, ном зохиол, нийтлэл өгүүлэл арвин бий. Бурханы сургаал нь цаг үе, газар орон бүхэнд тохирсон шинэлэг хэлбэрийг олж хөгжиж ирсэн уламжлалтай учраас тэр бүх судалгаа нь бурханы шашины хөгжилд нөлөөлөх нь дамжиггүй.

Бидний сэтгэлгээ ямагт нясваанис буюу «nyon mongs»-ын нөлөөнд автагдан хорлогдсон байдаг тул хязгаарлагдмал, түгжигдмэл болой, өөрөөр хэлбэл сэтгэл хөдлөлд автагдсан байх тул орчлон ертөнцийг байгаагаар нь ухаарч үл чадна, харин дадаж зуршсан бодрол сэтгэлгээгээрээ бий болгосон “дүрслэл төсөөллийн ертөнцөө” л ухаарч байдаг.

Бүхий л юмс үзэгдлийн бодьтой мөн чанарыг ухаарахад “шүтэн барилдлага” (mrDen 'brel)-ын зарчмыг мэдэхэд л хангалттай.

Бурханы сургаалын үндэс бол үзэл, явдал болой. Чингэхдээ, явдал нь бусдад хэрхэвч хор хүргэхгүй байх ёстой.

Энэ бол үл хүчирхийлэх, зовлонг хуваалцах, энэрэн нигүүлсэх бодьсэтгэлтний амьдрал, үйл хэргийн зарчим мөн.

Үзлийн тухайд гэвэл, буй бүхэн гадагшаа ч, дотогшоо ч шүтэн барилдаж, шалтгаан «tgyu» үрээрээ «'bras.» харилцан хамаарч, нөхцөлдөж оршино «las 'bras».

Хүний ухамсар сэтгэлийг судлан мэдэхийн тулд бурхан шашины бясалгал зан үйлийг сэтгэлээ төвлөрүүлэн гүйцэтгэж, дадуулах нь хамгийн зөв бөгөөд чухал арга болохыг Далай лам айлдал бүхэндээ тэмдэглэн хэлдэг. Хүн төрөлхтөн гадаад ертөнц, орчлон хорвоогийн явдлыг судлан гайхамшигтай үр дүнд хүрсэн ч хүн өөрийгөө буюу хүмүүн бидний ухамсар сэтгэлийг ухааралгүй орхигдуулсан билээ, харин бурханы сургаал аливаа юм үзэгдлийг цогц байдлаар тайлбарладгаараа илүү шинжлэх ухаанч сургаал мөн хэмээн тэрээр үздэг юм.

Үүний зэрэгцээ, Далай ламын тайлбарласнаар: “асуудлын нөгөө тал нь гэвэл – «шинжлэх ухааны судалгаагаар ямар нэг зүйлийг тодорхой хэмжээгээр баталсан, зарим нь туршлагаар нотлогдсон, тухайн судалгааны үр дүнд тодорхой баримт илэрсэн гэж бодъё л доо. Бүр тэр нь бурханы сургаалыг няцаах баримт байж болно. Шинжлэх ухааны үр дүнт бид ямар ч эргэлзээгүйгээр хүлээн авах ёстой. Тэгэхээр бид үргэлж баримтыг хүлээж авах

хэрэгтэй хэмээн бурханы сургаалд ч номлодог шүү дээ. Эмпирик баримтад тулгуурлаагүй санаанаасаа зохиосон цуу үг хэрхэвч байж таарахгүй. Ийнхүү 100% нотлогдсон туршлага нь шалгалтаар няцаагдвал чу"хам түүнийг л бид хүлээж авах учиртай" («Путь к себе» сэтгүүл. Москва 1995. №4 х.7). Алтыг шалгасны хойно л авдагтай адил өөрийнх нь үгийг шалгасны дараа л хүлээн авч итгэж үнэмших хэрэгтэй хэмээн бурхан багш шавь нартаа өөрөө айлдсан байдаг.

“Ирээдүйн шашин нь орчлонгийн уудмын шашин байх болно. Тэрээр тэнгэр бурханыг бие хүн мэт үздэг ойлголтыг ч, хэвшмэл номлолыг ч, шашины сургаалыг ч няцаана. Байгалийг ч, оюун ухааныг ч хамрах тэрхүү шашин нь байгалийн ч, оюун санааны ч бүх юм үзэгдлийн Нэгдлийг ухаарсан шашины сүсэг бишрэлд тулгуурлана. Энэ тодорхойлолтонд бурханы шашин тохирч байна. Орчин үеийн шинжлэх ухааны шаардлагад нийцсэн шашин байдаг бол тэр нь бурхан шашин мөн” хэмээн Альберт Эйнштейн дээрхи асуудлын талаар хэлсэн байдаг («Наука и религия» сэтгүүл. Москва 1987. х.31).

Их эрдэмтний гайхалтай зөнч бошго айлдал бидний энэ цагт биеллээ олж, Далай ламын ирээдүйн бус чухам энэ цагийн байгаль шинжээч тэргүүний эрдэмтэдтэй цөмийн физикийн хүрээнд ярилцсан хэлэлцүүлэг, санал солилцоо, лекцүүд үүний баталгаа болж байна. Энэ бүхнээс бурхан шашинд хэвшмэл номлол, хий хоосон номчирхол байхгүй гэдгийг бид мэдэж авлаа. Иймээс л Бурхан багш өөрийн сургаалаа “Дхарма”, «Jos.» буюу хууль ёс, байгалийн зарчим хэмээн нэрлэсэн билээ. Энэ бол ердөө л түүний өөрийнхөө хүчээр олж авсан үнэн бодит байдал мөн. Бурхан багш энэрэнгүй нигүүлсэнгүй сэтгэлээрээ бидний эргэн тойрон ертөнц, материаллаг юмс үзэгдэл бүгд шалтгааны үр дагавар «tgyu» буюу «las 'bras» гэдгийг бидэнд хэлж өгсөн юм.

Бурхан багш бас ахуй ертөнцийн мөн чанар, хоосон чанар «sTong pa»-ыг бидэнд нээн өгсөн. Ахуй ертөнц бол зовлон, түүний үйлчлэх арга механизм нь мөнх бус, энэ бүхэн мөхөж сүйрнэ, бас эргэн төрнө, тэгээд энэхүү зовлонгоос гэтлэх зам мөрийг зааж өгсөн. Энэ бол гэгээрлийн дөрвөн үнэн «bden bZi». Зовлонгоос гэтлэх цорын ганц арга бол ахуй ертөнцийн буюу бүх юмс үзэгдлийн хоосон мөн чанар буюу хоосон чанар «sTong nyid»-ыг ухаарах явдал болой. Хуучин ЗХУ-ын сансрын анхны нисэгчдийн нэг ийнхүү хэлсэн байдгийг би санаж байна: «Манай цэнхэр гариг ямар сайхан, бас жижигхэн, эмзэгхэн болох нь сансраас харагддаг. Түүнийг хамгаалж дэлхийн ирээдүй хойч үеийнхэндээ хадгалан үлдээх нь бидний үүрэг юм”. Энэ үгнээс Ламрим «Lam rim»-д бичигдсэн байдаг хэллэгүүд ямар их сонсогдож байна гээч: «Сансарын их далайд хөвөх жижиг завин дээр бүх төрөлхтөн хамт нэгнээ оршин байх мэт, далайг гэтлэн туулж чадах эсэх нь бид бүхнээс шалтгаална, хамгийн эхлээд онгоцны сайн жолоодогч, сайн ахмад лугаа бид сайн багшийг сонгох хэрэгтэй”. Сайн багш гэдэг бол хоосон чанар, бясалгал мөрийг сайн мэдэх хүн билээ. Иймээс хоосон чанарын онол нь Сансарын хүрднээс гарч зөв явах гол арга мөн.

Хоосон чанар нь хэлбэргүй, өнгөгүй, хүрэлцэн мэдэгдэшгүй, ухаарагдашгүй зүйл гэдэг нь мэдээж. Түүнийг объектив анализаар, бясалгалын тусламжтайгаар илрүүлж болно. Энэ бол хүмүүний сэтгэн бодох үйл ажиллагааны давуу чанар билээ. Хоосон чанарыг зөв илрүүлэхийн тулд объект, субъект хоёрын буюу санаа ухамсар, юмс үзэгдэл хоёрын харилцаа холбоог ухаарах нь нэн чухал. Энэ холбоог, нэгжээс ерөнхийд, тооноос чанарт шилжих харилцааг Дармакиртийн бичсэн «Tsad ma mdo» хэмээх шалгадаг ухааны шастирт дэлгэрэнгүй тайлбарласан буй. Энэ асуудлыг мөн эртний Грекийн алдарт

философич Платон зохиол бүтээлдээ хөгжүүлсэн байдаг. В.А. Канке “Философийн түүхэн ба системт курс”-дээ:

«Платон нь Сократын ойлголтыг хөгжүүлэхийг эрмэлзсэн юм. Юм бүхэнд түүний утга учир, үзэл санаа агуулагдан байдаг, үүгээр тухайн анги бүлгийн юм бүхэн *ганц*, тиймээс ч *ганц нэртэй* гэдэг нь тайлбарлагдана. Одой морь, ердийн морь гэх мэт олон янзын морь байдаг боловч бүгд моринд байх ганцхан л утгатай. Иймэрхүү байдлаар сайхан гэдгийг ерөнхий утгаар тайлбарлаж болно. Утга санааг авч үзэхгүйгээр ертөнцийн олон янз байдлыг даван туулах боломжгүй гэдэгт Платон итгэл төгс байгаа юм. Ганц зүйл олон зүйлсийн утга санаанд хэрхэн холбогдох вэ гэсэн асуудал гарна. Платон энэ асуудлыг хоёр талаас авч үзсэн байдаг. Тухайлбал, юмс үзэгдлээс утга санаанд шилжих шилжилт (юмс үзэгдэл → утга санаа), утга санаанаас юмс үзэгдэлд шилжих шилжилт (утга санаа → юмс үзэгдэл)». Дармакирти «tsad ma mdo.»-д мөн ингэж үзсэн байдаг. Жишээ нь, «bum pa» байгаа газарт юм (үлэг) байна, харин «sPyi» бол утга санаа нь, сэтгэл нь; «Ja bum pa» (шавар бумба), «lcags bum pa» (зэс бумба), «shing bum pa» (модон бумба) гэх мэт олон янзын «bum pa» буй, тэд бүгдээрээ «mi rtag pa» - «мөнх бус», ерөнхийдөө гэвэл: «bum pa mi rtag pa» буюу «юмс нь мөнх бус болой». Энэ үзэл санаа Платоны сэтгэлгээний аргатай нэн төстэй сонсогдож байна.

В.А. Канке “Философийн түүхэн ба системт курс” хэмээх бүтээлдээ Платон, Гегель зэрэг идеалист философичдын дэвшүүлсэн утга санаа гэгч нь чухам юу вэ гэсэн асуудлаар тэдний байр суурийг шүүмжилсэн юм. Жишээ нь, бид чулуу зэрэг юмсыг үлгэр болгон аваад түүнийг хүрэлцэн хүрч, барьж тэмтэрч болно, харин утга санааг нь тийнхүү хүрэлцэн мэдэрч чадахгүй. Үг гэдэг бол хүмүүний давуу чадвар. Платоны үзлээр утга санаа нь хүмүүн үгүйгээр оршин байдаг гэнэ. Гегель ч Платоны энэхүү үзлийг барьсан нь тодорхой. Гегелийн “санаа” хэмээгчийн системийг аваад үзэхэд тэр нь гурван бүрэлдэхүүн ойлголтоос тогтож байна: логикийн ухаан, оюун санааны философи, байгалийн философи гурав болой. “Санаа” хэмээх ойлголтоосоо Гегель аажмаар “оюун санааны философи”-руу эцэстээ шилжиж байгаа нь харагдана. Иймэрхүү шилжилт нь “Өөрөө орших ахуй” гэх мэт философийн түвшний үзэл баримтлал байх тохиолдолд боломжтой юм. Гегель бол Платоныг залгамжилсан объектив идеалист мөн гэдгийг В.А.Канке цаашдаа нотлоод, Гегелийн “Санаануудын” ангиллыг гаргажээ.

Гегелийн “Санаануудыг” ангилах схем

1. Логикийн ухаан (туйлын оюун санаа өөрөө) - «gang gzag bdag» (Бодгалийн Би)

Мөн чанарын тухай сургаал

Ахуйн тухай сургаал – ойлголтын тухай сургаал «yod pa, med pa»

2. Байгалийн философи (байгаль дахь туйлын оюун санаа) «dngos pa»

Механик - физик - органик физик

3. Оюун санааны философи (оюун ухаан дахь туйлын санаа) «shes pa»

Субъектив оюун санаа – объектив оюун санаа – туйлын оюун санаа «gnam mkhyen»

Бурханы сургаалд оршин ахуйг (оршин ахуй өөрөө буй бус хэмээн) тэс өөрөөр авч үздэг бөгөөд оршин ахуйг шүтэн барилдлагын хуулинд шүтүүлэн тайлбарласан нь бурханы сургаалтнуудыг чухам ийнхүү үзэхэд хүргэжээ. “Оршин ахуй ба Үзэл санаа”-г харилцан шүтэж үүсдэг хэмээн үзсэн тохиолдолд л логикийн хуулиар тайлбарлаж болох юм. Оршин ахуйн харьцангуй түвшинд “Үзэл санаа” хэмээх ойлголт нь объектив бодит байдлаар илрэх боломжтой.

Бидний хувьд материаллаг ертөнцөд цаг хугацаа, орон зай, үйл явдлын ээлж солигдол зэрэг ойлголтууд бодтой оршино. Гегелийн «Утга санаа»-г бурханы шашины

төв үзлийн төлөөлөгчид «yang dag pa'i kun brcob» (үнэхээрийн янагуухь) хэмээн нэрлэнэ. Нүд, чих гэх мэт мэдрэхүйн эрхтнүүдийнхээ нөлөөгөөр бид иймэрхүү үнэхээрийн дүр зургийг хардаг бөгөөд тэдгээр нь “өөрөө орших ахуй” буй гэдгийг бидэнд хэлж байдаг юм. Бурханы шашины төв үзлийг баримтлагчид утга санаа бол энэхүү үзэгдлийг няцаагч нь мөн хэмээн үздэг тэс өөр хандлагатай билээ. Тухайлбал, «Shir snying mdo» хэмээх сударт «нүд буй бус, чих буй бус, хамар буй бус» гэх мэтээр мэдрэхүйн эрхтнүүдээр (үнэхээр) хүртэх мэдлэг байхгүй хэмээн заасан буй. Үнэндээ бодит байдалд, бодит амьдралдаа бид мэдрэхүйн эрхтнүүддээ л тулгуурлана. Эрдэмтдийн судалж тогтоосноор бид 93%-ийн мэдээллийг мэдрэхүйн эрхтнүүдээрээ, үлдсэн 7%-ийг бусад эрхтнүүдээрээ хүлээж авдаг ажээ. Бид материаллаг ертөнцөд амьдарч байгаа учраас “Утга санаа” хэмээх ойлголтыг, харьцангуйн хуулийг удирдлага болгох ёстой.

Буддын философи дахь ангиллын схем

Буддын үзэл санааг ангилах нь:

«gang sag gi bdag med» - Туйлын оюун санаа

Yod pa – оршин ахуй

Med pa – няцаалт (оршин ауй буй бус)

Rtag pa – туйл

dNgos pa – матер

IDan min 'du byed. – бэлгэдэл ба ойлголтууд

gzugs – дүрс (объект)

Shes pa – мэдэл, ухамсар

Байгалийн философи

Логикийн ухаан - (өөрөөрөө байгаа туйлын оюун санаа)

(Байгаль дахь туйлын оюун санаа)

Механик - физик - органик физик

«nang gi gzugs ba» - амьд байгаль

«dbang shes lnga» – субъектив оюун санаа

Dbang po lnga – объектив оюун санаа

Бурханы сургаалтнууд харьцангуй (янагуухийг) авч үзэхдээ логик сэтгэлгээг удирдлага болгон ертөнцийг танин мэддэг. Энэ талаар бурхан багшийн хэлсэн нэгэн алдартай үг бий::

«Алтыг сайтар шигшиж хайлуулан

Жинлүүрт хэмждэгтэй адил

Санваартан бандида бүгдээрээ

Миний үгийг үг дуугүй дагах бус

Сайтар нягтлан шинжилж

Тунгаасны эцэст аваарай» хэмээсэн буй.

Тиймээс ч, логикийн хувьд зөрчилтэй нөхцөл байдлыг хүлээн авсан хүмүүнийг тухайн асуудлаар алдартай хэмээн үзэж болохгүй. Иймээс, логик сэтгэлгээ л объектив бодит байдлыг илрүүлэх үндсэн арга болж чадна.

Тэгвэл аливааг хэрхэн шинжлэн тунгаах вэ?

Үүний тул Бурхан багш “Дөрвөн үндэс”-ний зарчмыг тогтоосон билээ. Тухайлбал:

1. хувь хүний үзэлд бүү тулгуурла

2. Сургаалд тулгуурла

3. Сургаалыг судлахдаа үгэнд бүү тулгуурла

4. Утганд нь тулгуурла

Утга хэмээхийн тухайд:

Тайлбарласан утганд бүү тулгуурла

Илт утганд тулгуурла

Илт утга хэмээхийн тухайд:

Янагуухь (Ердийн ухамсар)-д бүү тулгуурла

Дээд билиг (хоосон чанарт)-г тулгуурла.

Аливаа юм үзэгдлийн утга санаа гарцаагүй гэдгийг тогтоохын тулд “Дөрвөн үндсийг” барьж шинжлэн тунгаах хэрэгтэй.

Платоны хувьд санаа нь юмсад байх ерөнхий чанар мөн.

Одоо В.А. Канкегийн тайлбарыг авч үзье:

«Энгийн физик объектүүд (биетүүдийг) аваад үзье. Хэсэг төмөр, хэсэг нүүрс, мөн тийм хэмжээний ус авъя. Энэ гурав гурвуулаа жинтэй. Чанараараа бол гурвуулаа адил, зөвхөн тооны хувьд л өөр өөр байна...»

«Объектуудын жинг тодорхойлохдоо бид тэдгээрийн төмөрлөгийн, эсвэл усны хэмжээг тогтооно, эдгээр нь аль алиных нь хувьд ерөнхий жин болох юм...»

«Ерөнхий (Санаа)-г үл хүлээн зөвшөөрөх нь шинжлэх ухааны хувьд дэндүү байж болшгүй зүйл».

«Ерөнхий ба тусгай шинжийн нэгдэл бол хүн төрөлхтөн хөгжлийнхөө явцад гарган авсан оршин ахуйн суурь үндэс мөн».

Яг ийм тайлбарыг бид «sKyabs 'gro» (Итгэл одуулах) судраас үзэж болно: «*thad dad inin, don gcig min*», ангид бус, нэгэн утгат бус (ерөнхий ч үгүй, нэгж ч үгүй). Үнэмлэхүй түвшинд «*sTong nyid*» (ерөнхий) Санаа үгүй, харьцангуй (янагуухийн) түвшинд (ерөнхий) санаа үгүй бол В.А.Канкегийн хэлснээр бид хэрхэн оршин байх билээ. Буддын төв үзэлтнүүд ч ерөнхийг няцаах боломжгүй хэмээн үздэг.

Физикийн агиллаар ч мөн биет зүйл ба энерги гэсэн хоёр субстанц байдаг. Эхнийх нь жинтэй, хоёр дахь нь жингүй. Сонгодог физикт жин хадгалах ба энерги хадгалах гэсэн хоёр хууль байдаг. Харьцангуйн онолоор жин ба энергийн хооронд зарчмын ялгаа байхгүй: энерги нь (газрын гадаргад үзүүлэх нарны гэрлийн даралт) жинтэй, жин нь (газрын татах хүчээр унаж байгаа биет нь ажил хийж байгаа учир потенциал энерги гаргана) энерги мөн. Жин ба энерги хадгалах хоёр хууль нь жин-энерги хадгалах гэсэн нэг л хууль болно.

Одоо эдгээр ойлголтыг хоосон чанарын онолоор тайлбарлахыг оролдъя: Юм үзэгдэл бол хоосон, хоосон гэдэг бол юм үзэгдэл мөн (Дүрс нь хоосон, хоосон нь дүрс болой) «*gzugs sdong pa nyid, sdong pa nyid gzugs so*» (жин нь энерги, энерги нь жин мөн).

«*sTong nyid*» буюу энергийг «*sNgags*» хэмээх тарнийн шастирт «Илт гэрэл» «*aod.gsl*» хэмээн нэрлэсэн байдаг.

Мөн хайлсан төмөр нь хөлдүү төмрөөс хүнд жинтэй байдгийн учир нь түүнд энерги өгөгдсөнтэй холбоотой. Бүх юм үзэгдлийн бодит байдлыг ухаарахын тулд “шүтэн барилдлагын” хуулийг мэдэхэд л хангалттай.

Төв үзлийн «*dbu ma 'jug pa*» сударт:

«*bum pai rten stong pa nyid*» буюу (санаагаараа гаргасан дүрслэл, шошго). Энд, «*Ten*»- суурь, тулгуур – хоосон. “Бодгалийн Би” буюу «*gang zag gi .dag*» нь өөрөө өөрөөрөө оршин байж чадахгүй тул аливаа үүсэл, илрэл нь олон хүчин зүйл, тааламжтай нөхцлөөс шалтгаална. Иймээс дээрхи судрын зохиогч бандита (Нагарджуна) хэлэхдээ, «*Ten*» болсон «*bum pa*» нь «*sTong pa*» (шүтэн барилдлага) мөн гэх нь нарийн нийлмэл бүтэцтэй «*bum pa*» буюу юмс нь шүтэн барилдаж оршино гэдгийг зааж байна, учир нь

«bum pa» хэмээхийг зохион бүтээгч нь хүмүүн, ваарыг бүтээх орчин нөхцөл нь шавар, гал, үйлийн үр, энэхүү ваар нь суурь, гол хэсэг, хоолой гэх мэт нарийн бүтэцтэй. Ваарыг бүрэлдэл хэсгүүдэд нь санаагаараа хуваалаа гэж бодоход “ваарнаас” юу ч үлдэхгүй. Түүний утга учир, үүрэг зориулалт нь хэрэггүй болно «don.bYednus.p...», “ваар” хэмээх нэрнээс өөр юу ч үлдэхгүй.

Ийнхүү хувааснаар бүх материаллаг юм үзэгдэл харилцан хамааралтайгаар шүтэн барилдаж оршино, юмс үзэгдэл хоосон мөн чанартай гэдгийг харуулна.

Хурд нэмэгчийг ажиллуулбал бид элементар хэсгүүд нь хэрхэн задарч “тэрэлт энерги туяарах” яг ийм дүр зургийг харж болно.

Цааш нь, Платоны үзлээр, юмс үзэгдлээс Санаанд, мөн Санаанаас эргэж юмс үзэгдэлд шилжих логик явц нь харилцан нэг нэгэндээ нөлөөлдөг ба шилжилтийн ямар ч бодит механизм байхгүйг харуулна.

Дээр өгүүлснээс дараахь дүгнэлтийг хийж болно: дангаараа тусгаар явагдах нэгээхэн ч механизм байхгүй бөгөөд байх боломжгүй, харин юмс ба санааны буюу шүтэн барилдлага л буй «sPhyi bye brag» («Tsad ma mdo» судраас). Түүнчлэн “цагаан” үгүй бол “хар” үгүй хэмээн нотолж болно. Ухамсар мэдлийн бүрэн гүйцэд жинхэнэ бодит мөн чанар (хоосон чанар) «sTong nyid» нь бидний төсөөллийг буюу өөрөө оршин ахуй ба бүрэн үл ахуй хоёрын хооронд байх аргагүй хязгаар үзлийг төв үзлийн «dmu ma 'jug pa» сургаалд үргэлж хэрэглэгддэг энгийн няцаалт «med pa»-аар тас цохино. Жирийн төлөв «Jes thabs»-т байгаа “бодит” дадал зуршлаас гарсны дараа ч ухаан санаа нь юмс үзэгдлийг харьцангуй үнэний түвшинд «kun bcob bden pa» шүтэн барилдуулж «Ген 'brel» ухаарсаар байх ба энэ нь юмс үзэгдлийг энгийн хүчин төгөлдөр байдлаар заан тэмдэглэх үндэс мөн боловч зүүд, зэрэглээ, усанд туссан сарны тусгал, хуурмаг дүрс мэт болой «sGu ma, gmi lam, chu zla ba».

Бид ухаанаараа юмсын харагдах дүрийг буюу тэрхүү дүрийн тэмдэглэгээг хүртэн мэдэрч байх үест, хоосон мөн чанарыг харж байх үест тэрхүү “Ухаан - мөр” нь бүхнийг хоосны нэгдэлд буюу шүтэн барилдлагад «sTong nyid» ухаардаг.

Эндээс, бүх юм үзэгдэл хоосон чанартай, бас илрэх чанартай, энэ хоёр бол үнэний хоёр түвшин мөн.

«don dam bden pa, kun bcob bden pa» буюу төв голч мөрийг гурав дахь талаас авч үзвэл: «gZi lam 'bras gsum». Энд, «gZi.» нь үндэс, янагуухь ба үнэмлэхүй хоёр үнэний холбоо «don dam bden pa, kun bcob bden pa»; Мөр – энэ нь хоёр чуулганаас бүрэлдэнэ «Tshogs gnyis», харин Үр «Nam mkhyen» нь хоёр биеийн холбоо: «gzugs sKu, chos sku.», сурвалжийн ерөнхий асуудал нь – хоосон чанар «stong nyid», энэ нь дөрвөн хязгаар, найман буруу үзэл болон аливаа үзлээс ангижирсан төлөв болой.

Матер

Ертөнцийг үзэх материалист үзэл нь идеалист үзлийн эсрэг тал мөн.

Материализм нь ертөнцийн объектив бодит байдлыг хүлээн зөвшөөрч үүсдэг ба үүгээрээ ч объектив нэгдлийг тайлбарлана. Идеализм нь ертөнцийн нэгдлийг оюун санааны үндсээр тайлбарлана. Ертөнцийн нэгдлийг сэтгэлгээнээс, сэрлээс, “туйлын оюун санаанаас” гарган авдаг. Ертөнцийн талаар санаж сэтгэх нь нэг байдаг учраас ертөнц нэг хэмээх нотолгоог тэд үндэс болгоно.

Материалистууд санаа ухамсрын элементүүд нь материаллаг эх загвартаа үнэхээр нэгдэж байвал л тэдгээрийг сэтгэлгээгээрээ мөн нэгтгэж болно хэмээх нотолгоогоороо идеализмыг шүүмжилдэг. Ертөнцийн нэгдэл нь түүний оршин ахуйд байгаа бус аа.

Ертөнц нэгдмэл байхаасаа өмнө оршин байх хэрэгтэй гэсэн материалистуудын логик байгууламж зөв байна. Ямарваа юм нэгдмэл, эсвэл ялгаатай гэдгээ харуулахын өмнө эхлээд өөрөө оршин байх хэрэгтэй учраас ингэж тайлбарлах нь зөв өө. Юмс үзэгдэл нь ерөнхий чанартай аваас харилцан нэгдмэл байх боломжтой. Эндээс үүдэн, юмс үзэгдэл нэг харилцаанд нэгдмэл байж болох боловч чанарын өөр харилцаанд ялгаатай байж бас болно.

Энэхүү нэгдмэл ба ялгаатай талыг Гегелийн авсан “Алим, лийр ялгаатай боловч үр жимс гэдгээрээ ерөнхий (нэгдмэл)” гэсэн жишээгээр тайлбарлаж болно.

Иймэрхүү жишээг бид буддын логикоос харж болно. Тухайлбал, буддын логикт ерөнхийгөөс нэгжид хандах харьцааг «bye brag» буй, харин «sPhyi» буй бус учраас «sPyi bye brag» болой гэсэн жишээгээр тайлбарладаг..

Энэ тохиолдолд бид үгээр хөөцөлдөх шардлагагүй учраас Гегелийн хийсвэрлэлээс зайлсхийж байна. (К. Маркс и Ф. Энгельс. Святое семейство, соч. т.2 стр. 63 – 66)

«Гегелийн сэтгэлгээний арга»

Би жинхэнэ алим, лийр, гүзээлзгэнэ, бүйлсээс “үр жимс” гэсэн ерөнхий ойлголт үүсгэн, цааш лавшруулан жинхэнэ үр жимсээс би өөрөө гаргаж авсан “үр жимс” хэмээх хийсвэр ойлголт надаас ангид өөрөө оршин буй мөн чанар төдийгүй лийр, алим зэргийн жинхэнэ мөн чанар хэмээн төсөөлснөөрөө би үгийн хойноос (спекулятив) хөөцөлдөн “үр жимсийг” лийр, алим зэргийн “субстанц” хэмээн тогтоодог. Эдгээр зүйлсийн хамгийн гол чанар нь тэдний жинхэнэ, мэдрэхүйн эрхтэнд хүртэгдэж байгаа ахуй байдал бус, харин би тэдгээрээс хийсвэрлэн гаргаж авсан мөн чанар, миний төсөөлөлд байгаа мөн чанар, “үр жимс” гэх ойлголт мөн. Ингээд би алим, лийр зэргийг “үр жимс”-ний модус, оршин байх энгийн хэлбэрүүд хэмээн тогтоодог.

Үнэндээ, мэдрэхүйн хүртэхүйгээр дэмжүүлдэг миний эцсийн бодомж алим, лийрээс, лийрийг бүйлсээс ялгана, гэхдээ мэдрэхүйн хүртэхүйг миний үгээр хөөцөлдсөн (спекулятив) оюун ухаан гол зүйл биш, ямар ч хамаагүй зүйл хэмээн тогтооно. Үгээр хөөцөлдсөн (спекулятив) оюун ухаан нь алимд байгаа “үр жимс” хэмээх чанарыг лийрт, лийрт байгаа чанарыг бүйлсэд харна. Өөр өөрийн чанараараа ялгаатай жинхэнэ үр жимсүүдийг хий хоосон зүйл гэж тооцно.

Ийнхүү Гегелийн хүчирхэг оюун ухаан хоосон чанарын тухай ойлголтод нэн ойрхон дөхөж очжээ. Тэрээр “субстанц” буюу “үр жимс” нь үр жимсний жинхэнэ мөн чанар хэмээгээд үүнийгээ “үнэмлэхүй чанар” хэмээх хий үг(спекулятив)-ээр тогтоохын оронд шүтэн барилдлагын хуулийг харьцангуйн түвшинд хэрэглэсэн бол л болох байлаа.

Материалистуудын шүүмжлэл (зөрчил):

Бүх эрдэс бодис жинхэнэ хэрэгтээ “ерөнхий эрдэс” мөн хэмээх үзлээр эрдэс судлаачид, эсвэл шинжлэх ухаан бүхэлдээ хязгаарласан бол тэр нь өөрийн хувийн төсөөллийн хүрээнд л эрдэс судлаач байх байсан. Эрдэс бодис илрэх тутамд иймэрхүү үгээр хөөцөлдсөн спекулятив эрдэс судлаач нь зөвхөн “энэ бол эрдэс мөн” хэмээн өгүүлж, энэ үгийг хичнээн л давтана төчнөөн тооны жинхэнэ эрдэс байгаа гэсэн үзлээр шинжлэх ухаан хязгаарлагдах байсан

Спекулятив сэтгэлгээ нь янз бүрийн бодит үрээс ганц хийсвэр “үр”, “ерөнхий үр” хэмээхийг гарган авч түүнийхээ бодит агуулгыг харуулахын тулд нөгөө л “үр” буюу субстанцаасаа олон янзын жинхэнэ ердийн үр жимс болох лийр, алим, бүйлс зэргийг тайлбарлахыг яаж ийгээд оролддог юм. Жинхэнэ үр жимсүүдээс ерөнхий хийсвэр “үр” гарган авахад хичнээн амар байдаг, төдий хэмжээгээр эргээд хийсвэр үрээс жинхэнэ үрийг гарган авахад хэцүү болдог билээ. Түүнээс гадна, хийсвэрлэлээсээ хагацахгүй бол хийсвэрээс гарч яагаад ч чадахгүй.

(Хэрвээ алим, лийр, бүйлс нь “ерөнхий үр” (субстанц)-ээс өөр юу ч биш гэвэл тэрхүү “ерөнхий үр” хэрхэн эсвэл алим, эсвэл лийрний хэлбэрээр надад харагдаад байна вэ, энэ олон янзын жимс яагаад байгаад байна вэ гэсэн асуулт ерөнхий нэгдлийн тухай миний спекулятив үгэн сэтгэлгээ, “ерөнхий үр” гэсэн төсөөлөлд минь тэрсэлдэн гарч ирж байна). “Ерөнхий үр” бол үхмэл, ямар ч ялгаагүй мөн чанар бус, харин ч амьд, өөрөө өөрөөсөө ялгарч байдаг, хөдөлж байдаг учраас энэ бүх олон янз байдал харагдаж байгаа юм хэмээн спекулятив философич хариулдаг. Ердийн үр жимсний олон янз байдал нь зөвхөн миний мэдрэхүйн бодомжинд төдийгүй “ерөнхий үр”-д өөрт нь ч, спекулятив оюун санаанд ч учир холбогдолтой. Янз бүрийн ердийн үр-жимсүүд нь “ерөнхий үр”-ийн амьдралын олон янз илрэл мөн, “ерөнхий үр” нь алим хэлбэртэй оршин ахуйгаа алимаар үзүүлж, лийр хэлбэрээ лийрээр үзүүлдэг гэх мэт. Жинхэнэ алим, жинхэнэ лийр нь “ерөнхий үр” хэмээх хийсвэр зүйлийг бий болгох учраас “ерөнхий үр” нь нэг тохиолдолд алимхэлбэрээ алимаар, нөгөө тохиолдолд лийр хэлбэрээ лийрээр илэрхийлдэг..

Энэ мэтчилэн субстанцийн тухай ойлголтоос эх авсан лийр бол “үр”, алим бол “үр” хэмээх үзлийг энд давтан давтан өгүүлэх хэрэггүй буй за. Харин ч “үр” бол лийр мөн, “үр” бол алим мөн хэмээн өгүүлбэл зохилтой.

Алим, лийр, бүйлс зэрэг нь “ерөнхий үр” өөрөөсөө өөрийгөө ялгаж буйн илрэл, тэдгээр нь “ерөнхий үр”-ийн амьдрах явцдаа янз бүрийн сувгаар гарган авсан тусгаар тусгаар үрийг боловсруулдаг. Ийнхүү, “үр” бол ямар ч утга агуулгагүй, ялгаваргүй нэгдмэл байдал бус аа. Энэ бол үрүүдийн цогц, нийлбэр чанар мөн бөгөөд “салаа мөчир сувгуудынх нь органик эгнээ хэсгүүд” болой. “Ерөнхий үр” гэдэг бол үзэгдэж харагдаж буй оршин ахуйн цорын ганц алим бус, цорын ганц лийр хэлбэрт зүйл ч бус, харин ч алим хэлбэрт, лийр хэлбэрт зүйлсийн зохицол нь үр мөн хэмээн өгүүлэх нь зүйтэй. Иймээс алим хэлбэрээр, лийр хэлбэрээр тус тусдаа байгаа зүйлсийг хараад “ерөнхий үр”-ийг, үрийн нийлбэр чанар бүхэлдээ төсөөлөгдөж байна хэмээн өгүүлж үл болно. Энэхүү үр нь салаа мөчир сувгуудынхаа дараа дараагийн эгнээ бүр дээр илүү хөгжингүй, илүү тодорхой илрэх оршин ахуйг үзүүлэх ба бүх үрүүдийн ерөнхий нэгдлийг илэрхийлэх үестээ үр бүрийг тус тусад нь өвөр дотроо найруулан агуулж, тэр хэмжээгээр өөрөөсөө үр бүрийг ялгаруулдаг амьд нэгдэл байхаа нэгэнт больдог байна. “Үр” хэмээх үг алим, лийрийг ч, бусад бүр жимсийг илэрхийлэх боловч нэгэн хотын оршин суугчдыг энэ хотын иргэн хэмээн бид бүхэлд нь ярьж чадахгүйтэй адил болой.

Спекулятив философи нь хэчнээн л юмс үзэгдэл байна, төдий хэмжээний хувилгаан дүрийг мэдэж байдаг, Жишээ нь, тэдний хувьд дээрхи тохиолдолд тусгаар үр бүхэн субстанцийн, туйлын үрийн онцгой хувилгаан дүр болдог. Үнэн чанартаа тэдгээр нь алим, лийр, бүйлс гэх мэт болой. Дахиад л үгээр хөцөлдсөн сэтгэлгээний спекулятив ертөнцөд бидэнтэй тааралдах алим, лийр, бүйлс нь оюун бодролоор гарган авсан “ерөнхий үр”-ийн буюу энэхүү хийсвэр чанарын амьдралын агшин болох учраас зүгээр л хий хоосон алим, лийр юм, тэдгээр нь өөрсдөө оюун бодролын хийсвэр бүтээл мөн болно. Эцсийн эцэст бид бүх жинхэнэ үрүүдээ олж авна, гэхдээ материаллаг хөрснөөс ургуулан авах бус, харин өөрсдийнхөө тархины агаараас “ерөнхий үр”-ийг буюу туйлын субъектын хувилгаан дүрийг гаргаж авна. Спекулятив хэлээр бол энэхүү үйл ажиллагаа нь субстанцийг субъект болгон, дотоод үйл явц болгон, туйлын бодгаль болгон ойлгож нэрлэнэ.

«Хүй нэгдлийн идеализм»: ерөнхий (ойлголт, үзэл санаа) нь тусгаар юм үзэгдэл мөн.

Орчин үеийн идеализм, Кант, Гегель, Эзэн тэнгэрийн үзэл санаа. Ширээ, сандал болон ширээ, сандалын тухай үзэл санаа, ертөнц болон ертөнцийн (Ертөнцийн эзний) тухай үзэл санаа нь бүхэлдээ хий хоосон санааны илэрхий хэсэг мөн.

Идеализм ба материализмын хоорондох энэхүү мөнхийн маргаан нь бидэнд буддын логикийн «Tshad ma mdo» судрыг сануулж байна.

Гегель “субстанц” бол “үр” гэж үзэж байгаа учраас түүний “Санаа”, “Туйлын санаа”-ны тухай ойлголт хоосон чанарын үзэлд дөхөж очно гэвэл ташаа зүйл болно. Тухайн тохиолдолд “юмсын өөрийн чанар”-ыг хүлээн зөвшөөрч байгаагаараа Гегель буруутай. Тэрээр юмсын мөн чанарыг няцаасан ойлголттой байх мэт боловч “юмсын өөрийн чанарыг” буюу “өөриэн оршин ахуй” гэсэн хэллэгийн утгыг бүхэлд нь янз бүрийн өнгө аясаар хүлээн зөвшөөрсөөр байгаа юм. Жишээ нь, “халуун” гэдэг бол галын чанар, “чийглэг, урсамтгай” гэдэг бол усны чанар мөн. Энэ тохиолдолд бид “өөрийн чанар” гэсэн ойлголтыг хэрэглэдэг. (Өөрөөр хэлбэл, бодьтой оршин байгаа аливаа юмыг тайлбарлахдаа “шинж чанар” гэсэн ойлголтыг хэрэглэдэгтэй адил). Мөн тэрчлэн үнэн хэрэгтэй өөртөө, өөрөө, бусдаас хамааралгүй орших юм үзэгдэл огт байхгүй атал “өөрийн оршихуй” гэсэн өөр нэгэн зүйл хэллэгийг хэрэглэдэг. Тодорхой нэр бүхий ямар нэгэн юм буй атал ямар ч тодорхой учир холбогдолд үл хамааруулан оршин ахуйн аль нэг хэлбэрийн тухай ийнхүү төсөөлдөг. Үнэндээ юмс өөрийн чанар, дотоод мөн чанараарынхаа хүчээр оршин тогтнодог. Тухайн объект болж байгаа тэр зүйл л түүний мөн чанар болж оршин ахуйг нь нөхцөлдүүлж байдаг. Энэхүү объектыг (логикоор) задлан хуваахад тухайн объектыг оршин байна гэдгийг нь харуулах өчүүхэн ч зүйл объектээс үл үлдэнэ.

Эхлээд харахад, Буддын философийн сургаалуудад “юмсын өөрийн чанар”-ыг тайлбарлахтай холбоотой иймэрхүү зөрчлүүд байх мэт ажиглагддаг. Үнэн хэрэгтээ буддын сургаалуудын янз бүрийн тайлбар нь суралцагсдын ойлголтын харьцангуй түвшнүүдэд зориулагдсан байдаг байна. Тухайлбал, доод хөлгөний хоёр сургаал ахуйн бодит байдлын үүднээс ухаардаг хүмүүст, сэтгэл төдийтний сургаал нь “бүх зүйлс ухаанаас гарна” гэсэн үзэлд талтай хүмүүст тус тус зориулагдсан бол, төв үзэлтнүүд оршин буй бүхнийг “нэр, тэмдэг, бэлгэдэл” хэмээн үзэх ба материалист ба идеалист үзлийн хоорондох оршин ахуйн тухай маргааныг бүрэн тасалж бүх юм үзэгдэл харилцан хамаарч үүсдэг учраас анхдагч, хоёрдогчийн тухай асуудлыг шийдвэрлэх аргагүй гэж үзнэ. Бодит оршин ахуйд итгэгч хүмүүс доод хөлгөний сургаалаар явж аажмаар дээш дээш ахисаар оршин ахуй өөрийн чанаргүй хэмээх хоосон чанарын ойлголтонд хүрнэ. Төв үзэлтнүүд бүх зүйлс бүрэлдэл хэсгүүдээс «cha bcas» тогтоно хэмээн зөв зүйтэй үздэг юм.

НОМ ЗҮЙ

- Tshad ma mdo
- Shir snying mdo.\
- Дармакирти, «Tshad ma mdo»
- Зонхав Лувсандагва, “Мөрийн гурван үндэс”
- В.А. Канке, «Философия: исторический и систематический курс» Москва 1999
- К. Маркс и Ф. Энгельс. Святое семейство, соч. т.2
- Нагаржуна, dbu ma 'jug pa
- «Наука и религия» сэтгүүл. Москва 1987
- «Путь к себе» сэтгүүл. Москва 1995. №4